

Ганболдын Бүрэнтөгс^{1✉}, Санжпэрлээгийн Энхболд²,
Эрдэнэ-Очирын Амарболд², И Нагён³

¹Монголын Үндэсний Музей, Монгол улс, Улаанбаатар

²Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн.

Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,

Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

³Солонгосын Үндэсний Музей, Солонгос улс, Сөүл

Хурхын хөндийд шинээр илрүүлсэн нэгэн хэрмийн тухай

Хураангуй. Сүүлийн жилүүдэд сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг зайнаас тандан судлах, тухайн биетийн байршлыг олж тогтоох агаар, дроны зураглалын хайгуулын шинэ арга зүй археологийн шинжлэх ухаанд нэвтэрч байгаа билээ. Энэхүү хэрмийг 2022 онд шинээр сансрын зургийн хайгуулаар Монголын Үндэсний музейн археологич¹ илрүүлэн олж, 2023 онд тандалт судалгаа, 2025 онд Мон-Сол төслийн хүрээнд судлаачид хамтран хэмжилтийг хийсэн байна. Уг хэрмийн үүрэг зориулалтыг Хэрлэн, Туул, Сэлэнгэ, Орхон, Тамир голын хөндийд орших Хүннүгийн хот суурины судалгаатай харьцуулсан ба энэ удаад Хурхын хөндийн хэрмийг илрүүлсэн нь Хүннүгийн хэрэмт хотуудын байршил, тархцын судалгаанд чухал хэрэглэгдэхүүн болж байна. Учир нь энэхүү хэрмийн тууриас холгүй Дуурлиг нарс, Бор булгийн хүннүгийн язгууртны бүлэг дурсгал тус тус нэг бүсэд байгаа нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Тиймээс энэхүү дурсгалын онцлог хэв шинжийг дахин нягтлахаар төлөвлөөд байна.

Түлхүүр үг: *Хэнтий нуруу, гурван баян, хурх гол, хүннү, хэрэм*

Burentugs Ganbold^{1✉}, Enkhbold Sanjperlee²,
Amarbold Erdene-Ochir², Lee Na Kyung³

¹National Museum of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

²Institute of Archaeology,

Mongolian Academy of Sciences Building-1,

Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

³National Museum of Korea, Seoul, Korea

About the recently discovered settlement in the Khurkh river valley

Abstract. In recent years, satellite remote sensing technology has been increasingly used for archaeological research to locate and study immovable historical and cultural monuments. In 2022, a researcher from the National Museum of Mongolia discovered the ruins of this ancient city through satellite imagery exploration. A preliminary study was conducted in 2023, and in 2025, further research and precise measurements of the site were carried out by joint researchers within the framework of the MON-SOL project. Regarding the function and purpose of the fortified settlements, previous studies have referred to Xiongnu-period settlements located in the valleys of the Kherlen, Tuul, Selenge, Orkhon, and Tamir rivers. The newly identified settlement along the Khurkh River now provides valuable data for understanding the satellite location of Xiongnu fortified settlements. Notably, near this settlement are two significant groups of Xiongnu aristocratic burials in the Duurlig Nars and Bor Bulag complexes. The settlement lies in the ancient valley known as Khurkhonag Jubur (this place noted in the Secret History of the Mongols) near the confluence of the Khurkh and Onon rivers, an area which encompasses archaeological remains from multiple historical periods. This region also represents one of the main concentrations of Xiongnu burials, underscoring its importance. Future studies aim to conduct a detailed research study of the rectangular structure irrigation channels surrounding this settlement to clarify its function.

Keywords: *Khentii mountain range, gurban bayan, khurkh river, xiongnu, settlement*

Удиртгал

Төв Азийн өргөн уудам нутгийг эрхшээн нэгэн үе хүчирхэгжин мандаж байсан Хүннүгийн эзэнт улстай холбогдох хот суурины судалгааны эхлэл XX зууны эхэнд холбогдоно (Сосновский, 1934, 150-156). Анх Буриадын Улаан-Үд хотын орчмоос Иволгын сууриныг илрүүлэн малтан судалснаас хойш Монгол болон ОХУ, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны нутгаас Хүннүгийн үед холбогдох 31 хот суурины туурийг илрүүлээд байна. (Энхболд, 2024: 236).

Манай хилийн гадна орших Хүннүгийн хот суурины дурсгалууд нь Өвөр Байгалд орших Иволгын суурин, Дурени (Дөрөө), Дурени-2, Баян-Өндөр, Доод Мангиртай, Ёнхор, Хакаст буй Абакан, Тувагийн Барык, Тээл, Кыйлыг Хов (Данилов, 2018, 74), Хятадын Шаньси мужийн нутагт буй Тунванчен, Дабаодун зэрэг байна (Obrusanszky, 2009). Монголоос илэрсэн Хүннүгийн хот суурины дурсгал 2022 оны байдлаар Зостын хэрэм, Талын гурван хэрэм, Харганы дөрвөлжин, Худгийн талын балгас, Цагаан чулуутын балгас, Дов дэрс, Заан хошууны хэрэм, Шувуутайн голын хэрэм, Баруун дөрөөгийн хэрэм, Баянбулагийн туурь, Мангасын хүрээ, Сайрын балгас, Бороогийн суурин, Гуа дов, Бүрхийн дөрвөлжин, Өндөр дов, Тэрэлжийн дөрвөлжин, Хүрээт дов, Овоотын баруун хавцлын туурь, Гуа дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Өндөр дов, Хүрээт дов, Цэнхэрийн голын хэрэм зэрэг 20 газар бүртгэгдээд байсан бол 2024 оны байдлаар Хандгайтын суурин 1, 2, 3, Дэрсэн хэрэм, Бүдүүний голын суурин, Чулуут голын хэрэм, Зүлэгтийн туурь гээд нийт 27 хот, суурины дурсгал бүртгээд байна (Энхболд, 2024, 236-237, 243).

Эдгээр хот суурины дурсгалууд нь байрлах газар нутаг, бүтэц зохион байгуулалт, үүрэг зориулалтын хувьд харилцан адилгүй юм. Тухайлбал, байрлалын хувьд Монголын төв, зүүн бүс нутаг, говийн бүсэд байрлах дурсгалууд хэмээн ялгаж үзэх боломжтой бол бүтэц зохион байгуулалтаар нь шороон хэрэмт хот, хэрэм бэхлэлтгүй орд өргөө, газар сууц бүхий суурин хэмээн хуваах боломжтой. Үүрэг зориулалтын хувьд засаг захиргааны төв, язгууртны орд өргөө, тахилын газар, хилийн бэхлэлт, гар урчуудын тосгон зэргээр ялгаж үзэх нь бий (Очир ба бусад, 2020, 24). Гэвч эдгээр дурсгалуудын цөөн хэдэд нь археологийн малтлага судалгаа хийгдсэн бөгөөд тус хотуудын нарийвчилсан он цаг, нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, эдийн засгийн ач холбогдол, хотын амьдралын хэв маяг зэрэг олон асуудал тодорхойгүй хэвээр байна.

Судалгааны арга зүй

Энэ удаагийн судалгаанд DJI компанийн Mavic 3 дрон ашиглаж гэрэл зургийг авсан ба 20 м тутамд нэг зураг авахаар тохируулж, системтэй,

төлөвлөгөөт нислэг үйлдсэний дараа Agisoft компанийн Metashape программыг ашиглан зургийг боловсруулав.

Уг дурсгал нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян 7 дугаар багийн нутагт сумын төвөөс зүүн хойд зүгт 57 километрт байрлана. Хурхын голын өмнө эргэцэгт 300 м, нутгийнхны нэрлэж заншсанаар Хурхын голын гармаас зүүн зүгт 5 гаруй км-т байрлана (Зураг 1).



Зураг 1. Хурхын голын хэрмийн байрлалыг харуулсан агаарын зураг

Дурсгал нь Хэнтий нурууны зүүн төгсгөлд орших Биндэрьяа хан, Хурхын гол, Дулын гозгор, Нарсан гул, Ёл зэрэг уулсаар хүрээлэгдэнэ. Эртнээс Биндэрьяа хан уулын ар, өвөр бэлээр олон гол урсах бөгөөд бүгд Хурхын гол руу цутгах ажээ. Харин өмнө зүгт 800 метр орчим зайд тариалангийн талбайн зах эхэлж байна.

Хэмжилт судалгаа. Хэрмийн хэмжээ 155x175 м.кв, хэрмийн далангийн өргөн 6,5 м, уртраг, өргөргийн дагуу зүүнээс баруун зүгт чиглэсэн тэгш хэмтэй, дөрвөн талдаа хаалгатай. Хэрмийн голд дөрвөлжин хэлбэрийн барилгын үлдэгдэл байгууламж байгаа нь төв ордон байсныг илтгэж байна. Уг туурь нь зүүн хойноос баруун урд чиглэлтэй 17x17 м хэмжээтэй.

Шороон хэрмийн гадна талаар ухмал шуудуу байх агаад ихэнх хэсэгтээ он цагийн уртад элэгджээ. Хэрмийн дотор талын баруун урд буланд 42,5x59,5 м хэмжээтэй барилгын туурь байгаа нь мэдэгдсэн ба 3 тасалгаатай, тасалгаа бүрд дугаар өгч хэмжилт хийв. 1-р тасалгаа 19,4 мx42,5 м, 2-р тасалгаа 21,3 мx42,5 м, 3-р тасалгаа 18,8 мx42,5 метр хэмжээтэй байлаа. Хэрмийн эргэн тойронд дөрвөлжин байгууламжууд байгаа нь энэхүү хэрэмтэй холбоотой байна.

Тус хэрэмд явуулсан бэсрэг хайгуулаар барилгын дээврийн тосгуур ваар 22 гаруй хагархайг өнгөн хөрснөөс түүвэрлэв. Одоогоор бүтэн хэмжээтэй дээврийн ваар олдоогүй байгаа бөгөөд хэрмийн баруун урд захын шороон далангаас

самнаа хээтэй тосгуур ваарны хагархайнууд олдсон нь он цаг тогтоох нөхцөлийг бүрдүүлээ. Бидний төлөвлөлтөөр сорилын малтлага хийсний дараа хүннүгийн шороон хэрэмт дурсгалуудтай харьцуулж, харилцан хамаарлыг тодруулах болно (Хүснэгт 1).






Барилгын материалын шаврын бүтэц, онцлог. Дээврийн тосгуур ваарыг маш нарийн ширхэгтэй хар хөх өнгийн шавраар хийсэн ба хагас дугуй модон хэвэнд ороон зүсжээ. Ингэхдээ нэг хэвээс дөрөв хүртэлх дээврийн ваарыг гаргаж авсан байна. Нумарсан гадаргуу бүхий, хагас зууван дээврийн





тосгуур ваарууд нь харилцан адилгүй хэмжээтэй ба өргөн нь 15-22 см, урт нь 18 см, зузаан нь 2,2 см. Дээврийн ваарны гадаргуу болон дотор талаар туушид нь олон эгнээ самнаа буюу босоо зураасыг гарган хээлжээ. Дээвэр ваарны үзүүр талаас их бие рүү 3,5 см хөндлөн шулуун зураасыг туушид нь гаргасан байна. Уг хэрмийн гадаад зохион байгуулалтын хувьд Хүннүгийн үеийн Талын гурван хэрэм, Хүрээт дов, Гуа дов, Өндөр дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин зэрэг хотуудын хэрмийн зохион байгуулалт, тэг, бүтцийн хэлбэртэй ижил байна (Зураг 2).



Зураг 2. Хүннүгийн хот суурины барилгын материал болох дээврийн тосгуур ваарны харьцуулалт:
 а. Хурхын хөндийн хэрмийн дээврийн тосгуур ваарны хагархай б. Гуа довын тосгуур ваарны хагархай
 с. Хүрээт довын дээврийн тосгуур ваарны хагархай.

Хүснэгт 1. Хэрлэн голын сав дагуух Хүннүгийн хот суурины дурсгалтай
Хурхын хөндийн хэрмийг харьцуулсан зураг

№	Дурсгалын нэр	Агаарын зураг	Дэвсгэр зураг
1	Бүрхийн дөрвөлжин		
2	Гуа дов		
3	Өндөр дов		
4	Тэрэлжийн дөрвөлжин		

5	Хүрээт дов		
6	Хурхын хөндийн хэрэм		
7	Овоотын баруун хавцлын туурь		

Дүгнэлт

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 7-р багийн Гурванбаян Хурхын хөндийгөөс шороон далант хэрмийг шинээр илрүүлэн баримтжуулав. Одоогоор хэрэм нь газрын өнгөн хөрсөн дээр мэдэгдэх төдий боловч тухайн үедээ мэдэгдэхүйц өндөр байсан бололтой. Иймээс хэрмийн хүрээг үйлдэхдээ ашигласан материалаас болсон уу? эсвэл түр оршин суух газар учир сайтар дэлдсэнгүй хийв үү? Ямартай ч хэрэм он цагийн уртад ихэд элэгдсэн байна.

Хэрмэнд сорилын малтлага хийгдээгүй байгаа бөгөөд Хэрлэн голын сав дагуу байгуулагдсан Хүннүгийн хотуудтай харьцуулахад гадаад зохион байгуулалтаараа адилхан ба дөрвөн талдаа хаалгатай, шавар хэрэмтэй, самнаа хээт дээврийн ваар зэрэг нь олон талаараа ижил байна.

Тухайн дурсгалд явуулсан бэсрэг хайгуулын үр дүнгээс үзэхэд барилгын тосгуур ваарны хагархайн их бие дээрх хээ, хэрмийн архитектурын төлөвлөлт, газар зүйн байршил, бүс нутгийн онцлог зэргийг харгалзан Хүннүгийн хэрэмт хот болохыг урьдчилсан байдлаар тогтоогоод байна.

Учир нь бидний судлан буй дурсгалтай байршлын хувьд хамгийн ойрхон байгаа хүннүгийн хот нь Баян-Овоо сумын Овоотын баруун хавцлын туурь болох юм. Эдгээрийн хэлбэр бүтцийг үзэхэд улирлын чанартай хэрэм байсан болов уу? хэмээн таамаглаж байна. Иймээс хамгийн ойр байгаагаар нь харьцуулан үзэж Хүннүгийн үед холбогдох магадлал өндөр хэмээн үзэж байна. Нөгөөтээгүүр энэхүү хотын тууриас холгүй Хүннүгийн язгууртны бүлэг булшны гол төвлөрөл нэг бүсэд байгаа нь анхаарлыг зүй ёсоор татаж байна.

Цаашид Хурхын голын ай савыг түшиглэн байгуулсан энэхүү хэрмийн бүтэц, үүрэг зориулалт, учир холбогдлыг тодруулах, газар зүйн мэдээллийн санд байршуулах, дурсгалын он цаг, эзэн холбогдогчийг тодруулах шаардлагатай байгаа билээ.

НОМ ЗҮЙ

Очир, А., Уртнасан, Э., Энхболд, С., Эрдэнэболд, Л., Эрэгзэн, Г. Монголын эртний хот суурин. *Монголын археологийн өв*. Х боть, Улаанбаатар, 2020.

Очир, А., Чэн Ёнжи., Анхбаяр, Б., Саранбилэг Ч., Чэн Пенфэй., Дандар. Шинэ олдсон хүннүгийн тахилгын байгууламжууд. *Nomadic Studies*. №24, Vol., 17, Улаанбаатар, 2017: 20-61.

Өлзийбаяр, С., Батсүрэн, Б., Уртнасан, Э., Одмагнай, Г., Цэгмэд, Э. Хүннүгийн дараах нүүдэлчид. *Археологийн судлал*. Том. XL, Fasc. 1, Улаанбаатар, 2019: 1-5.

Пэрлээ, Х. *Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон*. Хүн нарын хот суурин (МЭӨ 3 дугаар зуун-МЭ 1 дүгээр зуун). Хүн улсын Шаньюйн орд, харш-хот. Улаанбаатар, 1961.

Энхболд, С. Хэрлэн гол дагуу орших хүннүгийн хот, язгууртны ордын он цагийн асуудал.

Улаанбаатар, 2024: 236-237, 243.

Эрэгзэн, Г. Гуа Довын дурсгалын бүтэц, үүрэг зориулалтын талаарх шинэ таамаглал. *Археологийн судлал*. Том. XXXVI, Fasc. 13, Улаанбаатар, 2017: 191-210.

Данилов, С.В., Именохоев, Н.В., Нанзатов, Б.З., Эрдэнэболд, Л., Симухин, А.И., Тулуш, Д.К. Города эпохи хунну на территории Тувы. // *Геоархеология, Этнология, Антропология*. Том. 24, 2018: 74.

Сосновский, Г.П. Нижне-Иволгинское городище. *Проблемы истории докапиталистических обществ*. № 7-8, 1934: 150-156.

Obrusanszky, B. Tongwancheng, the City of Southern Huns. *Transoxiana* 14, 2009.

REFERENCES

Ochir, A., Urtnasan, E., Enkhbold, S., Erdenebold, L., Eregzen, G. Mongoliin ertnii khot suurin. -In: *Mongoliin arkheologiiin Öv* – X, Ulaanbaatar, 2020.

Ochir, A., Chen Yunji, Ankhbayar, B., Saranbileg, Ch., Chen Peipei, Dandar. Shine oldson khünnügiin takhilgiin baiguulamjuud. *Nomadic Studies*. 24, Vol. 17, Ulaanbaatar, 2017: 20-61.

Ölziibayar, S., Batsüren, B., Urtnasan, E., Odmagnai, G., Tsegmed, E. Khünnügiin daraakh nüudelchid. *Arkheologiiin sudlal*. Том. XL, Fasc. 1, Ulaanbaatar, 2019: 1-5.

Perlee, Kh. *Mongol ard ulsiin ert, dundad üyiin khot suurinii tovchoon*. Ulaanbaatar, 1961.

Enkhbold, S. *Kherlen gol daguu orshikh khünnügiin khot, yzguurnii ordiin on tsagiin asuudal*. Ulaanbaatar, 2024: 236–237, 243.

Eregzen, G. Gua Doviin dursgalin butets, uureg zoriulaltiin talaarkh shine taamaglal. *Arkheologiiin sudlal*. Том. XXXVI, Fasc. 13, Ulaanbaatar, 2017: 191–210.

Danilov, S.B., Imenokhov, N.B., Nanzatov, B. Z., Erdenebold, L., Simukhov, A. I., Tulush, D.K. Goroda epokhi khünnü na territorii Tubi. *Geoarkheologiy, Etnologiy, Antropologiy*. Том. 24, 2018: 74.

Obrusanszky, B. 2009. Tongwancheng, the City of Southern Huns. *Transoxiana* 14.

Sosnovskii, G. P. Nijni-Ivolginskoy gorodishi. *Problemy istorii dokapitalisticheskikh obshestb*. № 7-8, 1934: 150–156.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>